



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН  
АУДИТЫН ГАЗАР  
**АЛБАН ШААРДЛАГА**  
64101 Номгон, Баянхонгор сум  
Утас, факс 70-44-25-84  
E-mail: bayankhongor@audit.gov.mn

Г АЙМГИЙН ЗДТГ-ЫН САНХҮҮ, ТӨРИЙН 7  
САНГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА  
Д.БОЛДБААТАРТ

2015.10.21 № 38

### Зөрчил арилгах тухай

Үндэсний аудитын газрын 2015 оны аудитын болон ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Уул уурхайн нөхөн сэргээлтийн хөрөнгө төвлөрүүлэлт, зарцуулалт, үр дүнд хийсэн нийцлийн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Шинэжинст сумын ЗДТГазар 2013-2014 онд төвлөрсөн 2450,0 мянган төгрөгийг нохой устгах, 1000 цэцгийн баярын арга хэмжээ, чацарганы суулгац худалдан авах, байгаль хамгаалах өдөр тэмдэглэх, бараа материал худалдан авах болон нөхөн сэргээлтийн явцын хяналтад зарцуулсан шатахуун, Баянговь сум 2013-2014 онд төвлөрсөн 3000,0 мянган төгрөгийг ОНХС-гийн орлогоор бүртгэж зарцуулсан байна.

Энэ нь БОНХЯ-ны сайдын 2014.01.06-ны А-04 тоот тушаалаар батлагдсан Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансны гүйлгээнд хяналт тавих журмын 5.5. "Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх талаар хүлээсэн үүргээ биелүүлэх баталгаа болгож, тусгай дансанд байршуулсан мөнгөн хөрөнгийг энэхүү журамд зааснаас бусад зориулалтаар ашиглах, зарцуулахыг хориглоно." гэсэн заалтыг зөрчсөн байна.

Монгол Улсын Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1.12-р заалт, Монгол улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 тоот тушаалаар батлагдсан "Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах" журмын 2.1.1 "Бусдад өгөх төлбөр тооцоог зөрүүтэй тооцоолж олгосон" заалтыг үндэслэн ШААРДАХ НЬ:

Нэг. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн дагуу сумдын Төрийн сангийн дансанд байршуулсан хайгуулын тусгай зөрвшөөрөлтэй ААН-үүдийн барьцааны мөнгийг зориулалт бусаар зарцуулахгүй байх.

Хоёр. Хайгуулын барьцааны мөнгийг данс бүртгэлд зохих журам, стандартын дагуу тусгаж, тайлагнаж байх.

515017



Гурав. Зөрчлийг барагдуулж, хариуг 2015 оны 11-р сарын 15-ны дотор аймгийн Аудитын газарт ирүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Д Болдбаатар, аймгийн ерөнхий нягтлан бодогч Ц Самбууням нарт хариуцуулав.

Дээрх зөрчлийг арилгаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28.2 "Дараах тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ", 28.2.2."төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд" гэсэн заалтын дагуу шийдвэрлүүлэх болно.

АЛБАН ШААРДЛАГЫГ

БИЧСЭН:  
АХЛАХ АУДИТОР  Б.МӨНХБАТ

ЗӨВШӨӨРСӨН:

СТСХ-ийн ДАРГА  Д.БОЛДБААТАР  
ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ  Ц.САМБУУНЯМ